

ᠪᠠᠶ᠋ᠠᠨ-ᠥᠯᠭᠢᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

**АУДИТЫН КОД: БӨА-2025/001/НА-СТА-ТЕЗ**

**2025 ОН**

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3-4
	Товчилсон үгийн жагсаалт	5
Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН.....	6
	2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН .....	6
	2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН .....	6-7
	2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ..7	
	2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	7-8
Дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл	3. АУДИТЫН ТАЙЛАН .....	9
	3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	10
	3.1.1 Аудит хийсэн үндэслэл.....	10
	3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	10
	3.1.3 Аудитын арга зүй.....	10
	3.1.4 Материаллаг байдлын түвшин .....	9-10
Аудитын менежер Х.Женисбек	3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ.....	10
	3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж .....	11
	3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн.....	11
Ахлах аудитор Д.Назгүл	3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР.....	11
	3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан .....	11
	3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан.....	11
	3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	12
	3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан .....	11-12
	4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....	12
	4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ .....	12
	Төрийн сангийн мөнгөн хөрөнгө.....	13
2025 оны 4 дүгээр сар	4.2 АВЛАГА .....	13-14
	Төсөвт байгууллагын авлага .....	13-14
	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага.....	14
Уг тайланг YAГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү. <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a>	4.3 УРЬДЧИЛГАА .....	15
	4.4 БАРАА МАТЕРИАЛ .....	15-17
	4.5 ҮНДСЭН ХӨРӨНГӨ .....	17-18
	4.6 ӨР ТӨЛБӨР.....	18-21
	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр.....	18-21
	Төсөвт байгууллагын өр төлбөр.....	18-21
	4.7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО .....	20-21
	4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....	21
	ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн шууд захирагч, аж ахуй нэгж, төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар.....	21-22
	Орон нутгийн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар.....	22
	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар.....	22
	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар.....	22-23
	ТЕЗ-ийн харьяа Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.....	23-24
	4.9 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА .....	24
	4.10 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	24
	4.11 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	24
	4.12 ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ГАЗРУУДЫН ТАЛААР.....	25
	5.АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	25
	5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	25
	5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	25-26
	5.3 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийн нэгтгэл маягтууд хүснэгтээр.....	27-29
	5.4 АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ .....	30
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930 дугаарын утсаар хандана уу.		
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 1 дүгээр давхар 110, 112 тоот өрөө		

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Е.ЗАНГАР ТАНАА

2025.04.01 № 434  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. "Суат" ХХК-ны урт хугацаат зээлийн төлбөрт орон нутгийн төсвөөс төлсөн 430.5 сая төгрөгийн авлагаас эргэн төлөлт хийгдээгүй, он дамжсан 250.4 сая төгрөгийн төлөгдөх эсэх нь тодорхойгүй авлагыг тайлагнасан.

2. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 2,085.4 сая төгрөгийн материаллаг дүнтэй зөрчил илэрсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн 6.3.2, 6.4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.3, 5.1.4, 26 дугаар зүйлийн 26.1 дэх

832502000360

заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын толилуулга, иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2024 онд 80,779.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 70,758.5 сая төгрөг зарцуулж, 87.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Орон нутгийн суурь орлогод 39,825.8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 36,463.2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 8.4 хувиар тасарсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЖАЙГҮЛ

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
БОАЖГ	Байгаль орчих аялал жуулчлалын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,088,626.00</b>	<b>18,813,558.70</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,334,402.20	9,270,720.50
33	АВЛАГА	6,562,053.40	6,769,063.40
34	УРЬДЧИЛГАА	42,139.70	44,126.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,007,604.70	2,591,788.70
36	НӨӨЦИЙН БАРАА	142,426.00	137,860.10
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>109,319,222.40</b>	<b>125,362,537.40</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	109,319,222.40	125,362,537.40
39200	Биет хөрөнгө	100,614,761.40	116,616,410.10
39300	Биет бус хөрөнгө	8,704,461.00	8,746,127.30
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>127,407,848.40</b>	<b>144,176,096.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,550,574.60</b>	<b>9,297,381.30</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,661,495.70</b>	<b>6,728,573.50</b>
41200	Богино хугацаат зээлийн өглөг	396,586.40	568,838.60
41300	Өглөг	2,998,843.60	6,159,734.90
41400	Урьдчилж орсон орлого	266,065.60	-
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,889,079.00</b>	<b>2,568,807.70</b>
42200	Урт хугацаат зээл	2,889,079.00	2,568,807.70
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>120,857,273.70</b>	<b>134,878,714.80</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	120,857,273.70	134,878,714.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	37,819,469.10	38,987,297.68
51200	Хуримтлагдсан үр дүн	68,003,231.10	80,814,563.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,034,573.50	15,076,853.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>127,407,848.40</b>	<b>144,176,096.10</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>113,026,356.60</b>	<b>110,218,235.40</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>18,936,837.20</b>	<b>33,641,224.40</b>
110	Орлогын албан татвар	15,150,007.40	29,087,250.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	15,762,459.10	30,049,956.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,135,772.40)	(1,684,958.20)
1103	ААН-ын орлогын албан татвар	523,320.60	722,252.20
113	Хөрөнгийн албан татвар	1,499,596.60	1,690,121.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,287,233.20	2,863,852.90
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>61,588,224.00</b>	<b>64,786,623.21</b>
120	Нийтлэг татварын бус орлого	38,886,718.40	31,238,998.91
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22,701,505.60	33,547,624.30
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>32,501,295.40</b>	<b>11,790,387.70</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>50,641,265.70</b>	<b>76,189,003.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>50,641,265.70</b>	<b>76,189,003.60</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,683,972.50	74,316,162.70

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,505,119.90	19,913,126.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,420,621.50	2,623,783.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	968,308.90	14,271,403.00
2104	Хангамж, бараа материалын зардал	898,514.20	1,181,040.40
2105	Нормативт зардал	447,324.60	522,822.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	255,731.70	507,170.00
2107	Томилолт, зочны зардал	275,651.00	320,290.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,698,507.00	7,172,751.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,214,193.80</b>	<b>27,803,774.80</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>957,293.20</b>	<b>1,872,840.90</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>62,385,090.90</b>	<b>34,038,027.00</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>34,821,985.00</b>	<b>22,378,287.40</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>27,563,105.90</b>	<b>11,650,944.48</b>

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,491,722.30	-	92,491,722.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(681,885.50)	-	(681,885.50)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,809,836.90	-	91,809,836.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,484,331.00	-	1,484,331.00
9	Тайлант үеийн үр дүн	27,563,105.90	-	27,563,105.90
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,857,273.70	-	120,857,273.70
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	120,857,273.70	-	120,857,273.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,160,387.80	-	1,160,387.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,017,661.60	-	122,017,661.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	42,280.20	-	42,280.20
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,167,828.56	-	1,167,828.56
19	Тайлант үеийн үр дүн	11,650,944.48	-	11,650,944.48
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	134,878,714.80	-	134,878,714.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>95,086,044.80</b>	<b>101,816,782.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	18,622,119.50	33,641,224.40
110	Орлогын албан татвар	14,835,289.70	29,087,250.00

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

1100	Хувь хүний орлогын албан татвар	15,762,459.10	30,049,956.00
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	<b>(1,135,772.40)</b>	<b>(1,684,958.20)</b>
1103	ААН-ын орлогын албан татвар	208,602.90	722,252.20
113	Хөрөнгийн албан татвар	1,499,596.60	1,690,121.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,287,233.20	2,863,852.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	740,260.70	795,307.20
1181	Газрын төлбөр	291,557.00	469,417.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,255,415.50	1,599,128.30
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,962,731.90</b>	<b>56,569,339.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>21,261,226.30</b>	<b>23,021,715.00</b>
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22,701,505.60	33,547,624.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,501,193.50	11,606,218.20
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>51,344,672.50</b>	<b>71,471,642.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>51,344,672.50</b>	<b>71,471,642.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>50,387,379.20</b>	<b>69,598,801.70</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,593,503.50	22,565,231.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,166,744.70	3,435,054.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,246,843.90	14,015,056.10
2104	Хангамж, бараа материалын зардал	2,383,924.30	2,497,961.50
2105	Нормативт зардал	436,446.50	515,790.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	264,368.40	466,501.20
2107	Томилолт, зочны зардал	268,204.40	304,581.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,580,828.50	5,824,663.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,446,515.10	19,973,961.80
<b>212</b>	<b>ТАТААС</b>	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>957,293.20</b>	<b>1,872,840.90</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>43,741,372.40</b>	<b>30,345,139.40</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>40,750,722.90</b>	<b>30,236,568.90</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	40,750,722.90	30,236,568.90
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	40,750,722.90	30,236,568.90
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(40,750,722.90)</b>	<b>(30,236,568.90)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	(373,320.60)	(172,252.20)
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>373,320.60</b>	<b>172,252.20</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>2,617,328.80</b>	<b>(63,681.70)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,717,073.40	9,334,402.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,334,402.20	9,270,720.50

### **3. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **3.1 Үндсэн мэдээлэл**

3.1.1 Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

#### **3.1.2 Аудитын зорилт хамрах хүрээ**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын газар нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, орон нутгийн тусгай сангууд, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

#### **3.1.3 Аудитын арга зүй**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан, нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн №1-01/451 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.1.4 Материаллаг байдлын түвшин**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 50,641.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 506.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 354.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 25,547.7 сая төгрөгөөр нэмэгдсэн тул гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 76,189.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 761.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 533.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

### **3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ**

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, 54.4 дэх заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын хоорондын өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан дүнг төвлөрүүлэн захирагчийн тайлангаар 73,443.8 сая төгрөгөөр, ерөнхийлөн захирагчийн тайлангаар 25,258.9 сая төгрөгөөр нийт 98,702.8 сая төгрөгөөр тус тус устгах бичилт хийсэн. Устгах бичилтийн дүнг байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд харуулсан байна.
- Төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сан, төрийн сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.
- Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны А/629 дүгээр захирамжаар аймгийн Худалдан авах ажиллагааны газрын бүтэц орон тоог шинэчлэн баталсан байна. Тайлант онд аймгийн төвд Ерөнхий боловсролын сургууль 1, Хүүхдийн цэцэрлэг 6 нийтдээ 7 төсөвт байгууллага нэмэгдсэн байна.

#### **3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

#### **3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан

Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан

В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар,

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-20 дугаар тодруулгууд
Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

### 3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

#### 3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 144,483.9 сая төгрөг болж, өмнөх оноос 13.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,088.6	19,121.4	1,032.7	13.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	109,319.2	125,362.5	16,043.3	86.8
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>127,407.8</b>	<b>144,483.9</b>	<b>17,076.0</b>	<b>100.0</b>
Нийт өр төлбөр	6,550.6	9,605.2	3,054.6	51.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	120,857.3	134,878.7	14,021.4	48.3
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>127,407.8</b>	<b>144,483.9</b>	<b>17,076.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 17,076.0 сая төгрөгөөр өсөхөд тайлант онд УТХО болон ОНХО, аймаг сумын ОНХС-гаар бэлтгэгдсэн хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

#### 3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 11,650.9 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 12,390.3 сая төгрөг, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн 12.6 сая төгрөгийн төгрөгийн эерэг /орлого нь зардлаасаа их/ үзүүлэлттэй гарсан байна. Төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн -429.5 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд -322.5 сая төгрөг буюу хасах /зардал нь орлогоосоо их/ үзүүлэлттэй байна.

#### 3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 11,024.1 сая төгрөгөөр өссөн, тайлант үеийн үр дүн -15,912.2 сая төгрөгөөр буурсан байна.

#### 3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 101,816.8 сая төгрөг, зарлага 71,471.6 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 30,345.1 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлсэн байна.

#### 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

##### 4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 9,334.4 сая төгрөг болж, өмнөх оноос 2,617.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө	6.9	13.9	6.9	0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	9,327.5	9,256.9	(70.6)	99.9
<b>Дүн</b>	<b>9,334.4</b>	<b>9,270.7</b>	<b>(63.7)</b>	<b>100.0</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	3,713.5	3,986.6	273.1	43.0
Төсөл/ сан	870.7	735.7	(135.0)	8.0
Төрийн сан	2,962.3	2,802.7	(159.6)	30.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,787.9	1,745.7	(42.2)	18.8
<b>Дүн</b>	<b>9,334.4</b>	<b>9,270.7</b>	<b>(63.7)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 63.7 сая төгрөгөөр буурсан. Энэ нь оны эцэст төсөл сангийн үлдэгдэл 135.0 сая төгрөг, төрийн сангийн дансны үлдэгдэл 159.6 сая төгрөг, аж ахуй нэгжийн дансны үлдэгдэл 42.2 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна. Төсөвт байгууллагын дансны үлдэгдэл 273.1 сая төгрөгөөр өссөн байна.

Оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 6.9 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 9,327.5 сая төгрөг нь банканд байгаа бэлэн мөнгө байна.

Оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 13.9 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 9,256.9 сая төгрөг нь банканд байгаа бэлэн мөнгө байна. Банканд байршиж буй 9,256.9 сая төгрөгт гадаад валютаар байршсан мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Банканд байгаа 9,256.9 сая төгрөгийн 7,525.0 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл, 1,731.9 сая төгрөг нь арилжааны банкны үлдэгдэл байна. Үүнээс 3,986.6 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 735.7 сая төгрөг нь төсөл сангийн, 2,802.7 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 1,745.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит газруудын дансны үлдэгдэл байна.

##### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн харилцахын эхний үлдэгдэл 7,544.0 сая төгрөг байснаас 19.0 сая төгрөгөөр буурч оны эцэст 7,525.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт №3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>9,327.50</b>	<b>9,256.90</b>	<b>-70.60</b>	<b>100.00</b>
Төрийн сангийн харилцах	7,544.0	7,525.0	(19.0)	81.3

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Арилжааны банк дахь харилцах	1,783.5	1,731.9	(51.6)	18.7
<b>Дүн</b>	<b>9,327.5</b>	<b>9,256.9</b>	<b>(70.6)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлийн 81.3 хувийг төрийн сангийн, 18.7 хувийн арилжааны банкны харилцахын үлдэгдэл эзэлж байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 7,525.0 сая төгрөгийг задруулбал: 2,802.7 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны, 2,983.1 сая төгрөг нь ОНХС-ийн, 1,639.2 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, 71.0 сая төгрөг нь Замын сангийн, 28.4 сая төгрөг нь Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл, 0.6 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын дансны үлдэгдэл байна.

Арилжааны банк дахь харилцах мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,726.1 сая төгрөг нь 3 ОНӨААН-ийн, 5.8 сая төгрөг нь 2 сумын ЭЭС-гийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой гараагүй байна.

## 4.2 Авлага

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 7,076.8 сая төгрөг болж, өмнөх оноос 514.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Авлагын үлдэгдэл төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчтай холбогдсон авлага	17.9	43.2	25.3	0.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	388.3	669.7	281.4	9.5
Татаас, санхүүжилтийн авлага	307.8	307.8	-	4.3
Зээлийн хүүгийн авлага	43.1	49.6	6.4	0.7
Дансны авлага /ТӨҮГ/	6.5	-	(6.5)	-
Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	-	-	-
<b>Бусад авлага</b>	<b>2,261.2</b>	<b>3,104.1</b>	<b>842.9</b>	
Байгууллагаас авах авлага	2,205.4	3,059.9	854.5	43.2
Хувь хүмүүсээс авах авлага	55.8	44.2	(11.6)	0.6
<b>Зээлийн авлага</b>	<b>3,537.1</b>	<b>2,902.5</b>	<b>(634.7)</b>	
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	250.4	250.4	-	3.5
Хувь хүмүүст олгосон зээл	3,286.7	2,652.1	(634.7)	37.5
<b>Дүн</b>	<b>6,562.0</b>	<b>7,076.8</b>	<b>514.8</b>	<b>100.0</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төрийн сан	991.6	1,163.9	172.3	16.4
Төсөвт байгууллага	2,222.9	2,110.9	(112.0)	29.8
ОНӨҮГ	2,038.8	2,793.3	754.5	39.5
Төсөл/ сан	1,308.7	1,008.7	(300.0)	14.3
<b>Дүн</b>	<b>6,562.0</b>	<b>7,076.8</b>	<b>514.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 514.8 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбогдсон авлага 25.3 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 6.4 сая төгрөгөөр, төлбөртэй

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

үйлчилгээний авлага 281.4 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 854.5 сая төгрөгөөр өсөж, хувь хүмүүсээс авах авлага 11.6 сая төгрөгөөр, зээлийн авлага 634.7 сая төгрөгөөр орон нутгийн өмчид үйлдвэрийн газрын дансны авлага 6.5 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Байгууллагаас авах авлага 281.4 сая төгрөгөөр өсөхөд Цахилгаан шугам сүлжээний газрын авлага 663.3 сая төгрөгөөр, орон нутгийн ерөнхий орлогын авлага 172.2 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Нийт авлагын үлдэгдлийн 16.4 хувь буюу 1,163.8 сая төгрөгийг төрийн сангийн, 29.8 хувь буюу 2,110.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 39.5 хувь буюу 2,793.3 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн, 14.3 хувь буюу 1,008.7 сая төгрөгийг төсөл, сангийн авлага эзэлж байна.

Төрийн санд 1,163.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байснаас Аймгийн Орон нутгийн ерөнхий орлого 1,157.5 сая төгрөгийн, Баяннуур сумын Орон нутгийн ерөнхий орлого 3.4 сая төгрөгийн, Дэлүүн сумын Орон нутгийн ерөнхий орлого 2.9 сая төгрөгийн авлагатай байна.

Аймгийн Орон нутгийн ерөнхий орлогын 1,157.5 сая төгрөгийн авлагын 304.3 сая төгрөг нь Өлгий сумаас аймагт төвлөрүүлэх тэгшитгэлийн авлага, 250.4 сая төгрөг нь олон жил он дамжсан авлага, 430.5 сая төгрөг нь “Суат” ХХК-ийн урт хугацаат зээлийн төлбөрт төлсөн тухайн компаниас авах авлага байна. Хувь хүмүүст олгосон зээлийн авлага өмнөх оноос 634.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №5. Авлагын үлдэгдэл сумаар

<i>/сая төгрөгөөр/</i>					
Д/Д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	Алтай	204.40	162.00	(42.40)	6.1
2	Алтанцөгц	152.00	111.10	(40.90)	4.2
3	Баяннуур	183.80	238.10	54.30	9.0
4	Бугат	150.30	107.30	(43.00)	4.0
5	Булган	181.70	169.70	(12.00)	6.4
6	Буянт	155.00	151.20	(3.80)	5.7
7	Дэлүүн	221.50	94.40	(127.10)	3.6
8	Ногооннуур	201.70	163.60	(38.10)	6.2
9	Сагсай	215.10	157.20	(57.90)	5.9
10	Толбо	153.70	142.20	(11.50)	5.4
11	Улаанхус	299.10	221.10	(78.00)	8.3
12	Цэнгэл	377.60	350.80	(26.80)	13.2
13	Өлгий	790.80	583.40	(207.40)	22.0
	<b>Нийт</b>	<b>3286.7</b>	<b>2652.1</b>	<b>(634.60)</b>	<b>100</b>

Эх сурвалж: Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Баяннуур сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага өмнөх оноос 54.3 сая төгрөгөөр өсөж, бусад сумуудын зээлийн авлага буурсан нь хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэл буурсантай холбоотой байна. Нийт зээлийн авлагын үлдэгдлийн 22 хувь буюу 583.4 сая төгрөг нь Өлгий сумын, 13.2 хувь буюу 350.8 сая төгрөг нь Цэнгэл сумын, 9.0 хувь буюу 238.1 сая төгрөг нь Баяннуур сумын, 8.3 хувь буюу 221.1 сая төгрөг нь Улаанхус сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй 273.6 сая төгрөг /Буянт сумын Хоршоо хөгжүүлэх сан 128.9 сая

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

*төгрөг, Ногооннуур сумын ХХС 39.7 сая төгрөг, Сагсай ХХС 16.8 сая төгрөг, Цэнгэл ХХС 88.2 сая төгрөг/,*

- *Цахилгаан шугам сүлжээний газрын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй авлага 996.6 сая төгрөг, Барилга захиалагчийн алба санхүүгийн тайланд авлагыг зөрүүтэй тайлагнасан 3.1 сая төгрөг байна.*

#### 4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 44.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	13.4	31.1	17.7	70.5
Төсөвт байгууллага	28.8	13.0	-15.8	29.5
<b>Дүн</b>	<b>42.2</b>	<b>44.1</b>	<b>1.9</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

“Суат” ХХК урьдчилгаа дансанд өмнөх онд 13.4 сая төгрөгийн төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь барагдаагүй, БОАЖГ-ын өмнөх оны “ПГЖМ” ХХК-аас нийлүүлэх тракторын үнийн 50 хувийн урьдчилж гарсан 28.7 сая төгрөгийн зардлаас 25.8 сая төгрөг барагдаж 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд шинээр Дэлүүн сумын ЗДТГ-ын 10.0 сая төгрөгийн, Өрхийн эрүүл мэндийн төвийн 17.7 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал өмнөх оноос нийт дүнгээр 1.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт: *ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар урьдчилгаа данстай холбоотой зөрчил гараагүй байна.*

#### 4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын дансны оны эцсийн үлдэгдэл 2,591.7 сая төгрөг болж, оны эхнээс 584.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Бараа материалын үлдэгдэл төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	1,383.8	1,428.6	44.8	55.1
Төсөл/ сан				
ОНӨҮГ	623.8	1,163.1	539.3	44.9
<b>Дүн</b>	<b>2,007.60</b>	<b>2,591.70</b>	<b>584.1</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэл 584.1 сая төгрөгөөр нэмэгдэхэд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бараа материалын өсөлт нөлөөлжээ. Тухайлбал, Цахилгаан шугам сүлжээний газрын сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдэл 591.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *Бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргаж тайлагнаагүй 237.5 сая төгрөг /Алтай сумын Засаг даргын тамгын газар 3.9 сая төгрөг, “Жансая” өрхийн эрүүл мэндийн эмнэлэг 109.1 сая төгрөг, “Раушан” өрхийн*

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

эрүүл мэндийн төв 124.5 сая төгрөг;

- Барилга захиалагчийн алба анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, бараа материал тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй 57.5 сая төгрөг;
- Ашиглах боломжгүй болсон бараа материалыг холбогдох шийдвэр гаргаж актлаагүй 82.9 сая төгрөг /Байгаль орчин, аялал жуулчлалын газар 25.4 сая төгрөг, Цагааннуур захирагчийн алба 57.5 сая төгрөг/

## Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 137.9 сая төгрөг болж, өмнөх оноос 5.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	142.9	137.9	(5.0)	100.0
<b>Дүн</b>	<b>142.9</b>	<b>137.9</b>	<b>(5.0)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансанд 115.8 сая төгрөгийн аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн 5 сумын өвс, тэжээлийн нөөц, 22.1 сая төгрөгийн аймгийн ОНӨГ-ын дансанд бүртгэлтэй байгууллагуудад олгогдоогүй он дамжсан бараа материалын үлдэгдэл байна.

## ХАНГАМЖИЙН БАРАА МАТЕРИАЛ

Хангамжийн бараа материал өмнөх оноос 623.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №9. Хангамжийн материал төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	1160.1	1140.2	-19.90	50.8
Төсөл/ сан				
ОНӨҮГ	460.8	1103.8	643.00	49.2
<b>Дүн</b>	<b>1,620.90</b>	<b>2,244.00</b>	<b>623.10</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хангамжийн бараа материалын үлдэгдэл 623.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон төсөл сангийн бараа материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгө нэмэгдсэн нь Цахилгаан шугам сүлжээний газрын бараа материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хангамжийн бараа материалын үлдэгдлийн 50.8 хувийг буюу 1,140.2 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын, 49.2 хувийг буюу 1,103.8 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн материалын үлдэгдэл эзэлж байна.

Тайлант оны эцэст 17.4 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 484.7 сая төгрөгийн аж ахуйн материал, 1,061.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 66.4 сая төгрөгийн түлш, шатах тослох материал, 9.5 сая төгрөгийн барилгын засварын материал, 603.9 сая төгрөгийн бусад хангамжийн материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Жолоочийн шатахууны зарцуулалтын тооцоог зохих журмын дагуу хийгээгүй, замын хуудасгүй, шатахууны зарцуулалтыг нормын дагуу тооцож олгоогүй нийт 90.5 сая төгрөг /Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар 1.6 сая төгрөг, Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар 19.5 сая төгрөг, Ногооннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 9.9 сая төгрөг, Улаанхус сумын Засаг даргын тамгын газар 47.2 сая төгрөг, Цагааннуур захирагчийн алба 12.3 сая төгрөг/
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 14.3 сая төгрөг

**МАЛ АМЬТАД**

Мал амьтад дансны үлдэгдэл өмнөх оноос 62.6 сая төгрөгөөр буурч 37.2 сая төгрөгийн үзүүлэлттэй байгаа нь Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын данс дахь малын үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Улаанхус сумын Засаг даргын тамгын газар нь бараа материалын мал амьтад дансанд 9.9 сая төгрөгийн үнэтэй 62 толгой бог мал бүртгэлтэй байгаа боловч бодитоор байхгүй байгааг санхүүгийн тайланд үлдээдлээр тайлагнасан байна.

**4.5 ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 125,362.5 сая төгрөг болж, өмнөх оноос 16,043.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	100,614.8	116,616.5	16,001.7	93.0
Биет бус хөрөнгө	8,704.5	8,746.1	41.6	7.0
<b>Дүн</b>	<b>109,319.3</b>	<b>125,362.6</b>	<b>16,043.3</b>	<b>100.0</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	92,116.9	107,642.1	15,525.1	85.9
Төсөл/ сан	0.5	0.3	(0.2)	0.00
Төрийн сан				
ТӨҮГ болон ОНӨҮГ	17,201.8	17,720.2	518.4	14.1
<b>Дүн</b>	<b>109,319.2</b>	<b>125,362.5</b>	<b>16,043.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 107,642.1 сая төгрөг буюу 85.9 хувийг төсөвт байгууллагын, 17,720.2 сая төгрөгийн буюу 14.1 хувийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,412.6 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 1,778.8 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 20,561.9 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 64.5 сая төгрөг, дахин үнэлгээний 42.8 сая төгрөгөөр нийтдээ 23,860.6 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан 94.8 сая төгрөг, балансаас

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

баланст шилжүүлсэн 837.0 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 58.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

### **Дуусаагүй барилга байгууламжийн талаар:**

Дуусаагүй барилга данс оны эхэнд 3,599.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэйгээс 200.0 сая төгрөгийн Алтанцөгц сумын ЗДТГ-ын зам гүүрний байгууламж дансанд бүртгэгдэж оны эцэст 3,399.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд 2023 онд Орон нутгийн өмчийн газрын дансанд 3,229.8 сая төгрөгийн 2019 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “1000, 900 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээ” барилга, байгууламж дуусаагүй барилгаар бүртгэгдсэн ба зарим дэд станцыг шалгах боломжгүй шалтгаантай Улсын комисс бүрэн хүлээж аваагүй /ус, цахилгааны инженерүүд газар доорх байгууламж шалгах боломжгүй гэх тайлбартай/ байна. Аймгийн ОНӨГ-аас тодруулахад 2023 онд дуусаагүй барилгаар бүртгэгдсэн дээрх байгууламжийг эзэмшигч, ашиглагч байгууллага тодорхойгүй учраас 2024 онд ТӨБЗГ-т Өлгий сумын ЗДТГ-ын дансанд шилжүүлэх саналыг хүргүүлсэн одоогоор хариу ирээгүй гэсэн тайлбар өгсөн. Дээрх барилга байгууламжийн бүрэн бүтэн байдалд гэрээгээр 1 хүн авч ажиллуулсан байна.

Мөн дансанд 170.0 сая төгрөгийн төслөөр баригдсан аймгийн Асрамжийн газрын барилга нь ашиглалтад ороод 2 жил болсон одоог хүртэл Улсын комисс хүлээж аваагүй байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд нийтдээ 6,925.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой 509.1 сая төгрөгийн дараах зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийж баталгаажуулаагүй, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогод аваагүй /Өлгий сумын ИТХ 11.6 сая төгрөг, Алтай сумын ЗДТГ 60.8 сая төгрөг, аймгийн ЗДТГ 36.0 сая төгрөг, аймгийн Асрамжийн газар 163.1 сая төгрөг, Цагааннуур тосгоны захирагчийн алба 47.9 сая төгрөг, Барилга захиалагчийн алба 30.2 сая төгрөг/
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй /Алтанцөгц сумын ЗДТГ, Баяннуур сумын ЗДТГ 89.7 сая төгрөг, Орон нутгийн олон нийтийн радио, телевиз 62.8 сая төгрөг/

## **4.6 ӨР ТӨЛБӨР**

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 9,605.2 сая төгрөг болж өмнөх оноос 3,054.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №11. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,661.50</b>	<b>7,036.37</b>	<b>3,374.87</b>	<b>73.26</b>
Богино хугацаат зээлийн өглөг	396.59	568.84	172.25	5.92
Өглөг	2,998.84	6,467.53	3,468.68	67.33
Урьдчилж орсон орлого	266.07	-	(266.07)	0
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,889.08</b>	<b>2,568.81</b>	<b>(320.27)</b>	<b>26.74</b>
Урт хугацаат зээл	2,889.08	2,568.81	(320.27)	26.74
<b>Дүн</b>	<b>6,550.57</b>	<b>9,605.17</b>	<b>3,054.60</b>	<b>100.00</b>
ОНӨҮГазар	4,834.67	4,625.77	(208.90)	48.16

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Төрийн сан	309.30	309.30	-	3.22
Төсөвт байгууллага	1,406.60	4,670.10	3,263.50	48.62
<b>Дүн</b>	<b>6550.57</b>	<b>9605.17</b>	<b>3054.60</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр 9,605.2 сая төгрөг болж өссөн нь төсөвт байгууллагын өглөг 3,263.5 сая төгрөгөөр өсөж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өглөг 208.9 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөр 7,036.3 сая төгрөг болж өмнөх оноос 3,374.8 сая төгрөгөөр нэмэгдсэнд өглөг дансны үлдэгдэл нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт №12. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	42.66	190.02	147.36	2.94
Бараа үйлчилгээний зардлын өглөг	60.36	186.82	126.46	2.89
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	307.79	307.79	-	4.76
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	1,029.37	1,029.37	15.92
Зээлийн хүүгийн өглөг	36.30	33.90	(2.40)	0.52
Байгууллагад төлөх өглөг	2,282.46	4,641.06	2,358.60	71.76
Хувь хүмүүст төлөх өглөг	45.08	51.33	6.25	0.79
Татварын өглөг /ТӨҮГ/	192.17	24.57	(167.60)	0.38
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	26.32	2.67	(23.65)	0.04
Дансны өглөг /ТӨҮГ/	5.70	-	(5.70)	-
<b>Дүн</b>	<b>2,998.84</b>	<b>6,467.53</b>	<b>3,468.68</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөг дансны үлдэгдэл 6,467.5 сая төгрөг болж өмнөх оноос 3,468.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажилчидтай холбогдсон өглөг 147.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 126.4 сая төгрөгөөр, хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг 1,029.3 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 2,358.6 сая төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөг 6.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Өрийн өсөлтийн шалтгаан нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүждэг байгууллагуудын байр ашиглалтын зардалтай холбоотой өглөг тухайн байгууллагуудын улсын төсвийн тайланд тайлагнагдсан байсныг 2024 оноос орон нутгийн тайланд шилжүүлэн бүртгэсэн, мөн он дамжсан байр ашиглалтын зардлын өглөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх боломжгүй, орон нутгийн татварын орлого тасарсантай холбоотой үүссэн болно.

Аж ахуйн нэгжүүдээс ЦШСГ-ын өглөг 513.3 сая төгрөгөөр, “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын өглөг 6.0 сая төгрөгөөр нэмэгдэж, “Суат” ХХК-ны өглөг 37.4 сая төгрөгөөр, “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын өглөг 368.3 сая төгрөгөөр буурсан байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 266.1 сая төгрөгөөр буурсан нь “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын он дамжсан 266.1 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдлийг балансын гадуур бүртгэсэнтэй холбоотой байна.

## УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 2,568.8 сая төгрөг болж өмнөх оноос 320.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №13. Урт хугацаат өр төлбөр байгууллагаар

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
"Суат" ОНӨААТҮГ	594.5	422.2	(172.3)	16.4
ЦШСГазар ОНӨААТҮГ	2,136.6	2,136.0	-	83.2
"Жана-Өлке" ОНӨААТҮГ	138.0	-	(138.0)	-
Хала-Өркени ОНӨААТҮГ	20.0	10.0	(10.0)	0.4
<b>Дүн</b>	<b>2,889.1</b>	<b>2,568.8</b>	<b>(320.3)</b>	<b>100.0</b>

Урт хугацаат өр төлбөрийн дүн буурахад “Суат” ХХК-ны урт хугацаат зээлийн үлдэгдэл 172.3 сая төгрөгөөр, “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын зээлийн үлдэгдэл 138.0 сая төгрөгөөр, “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын зээлийн үлдэгдэл 10.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

"Жана өлке" ХХК нь аймгийн ИТХ-ын шийдвэрээр 2021 онд татан буугдсан байгаа тул тайлангийн нэгтгэлд ороогүй, тухайн байгууллагын тайланд бүртгэгдсэн өр төлбөрийг балансын гадуур бүртгэж тэмдэглэсэн байна. Үүнд: “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын 102.2 сая төгрөгийн өглөг, Урьдчилж орсон орлого дансны 266.1 сая төгрөг/аймгийн ОНХС-гаас 2014 онд олгосон 200.0 сая төгрөгийн зээл, иргэдээс урьдчилж авсан түрээсийн төлбөрийн 66.0 сая төгрөгийн өглөг/-ийн үлдэгдэл, Урт хугацаат өр төлбөрийн хувь хүмүүсийн зээлийн эхний үлдэгдлээс 138.0 сая төгрөг /иргэдээс павильоны анхны тавилтын үнийн урьдчилгаанд авсан/-ийн өр төлбөр байна.

Сангийн яам "Суат" ХХК-ний авсан урт хугацаат зээлийг аймгийн төрийн сангаас жил бүр хэсэгчлэн хуваарилж, төлүүлж байгаа бөгөөд энэ хэмжээгээр урт хугацаат зээлээс хасаж богино хугацаат зээлд шилжүүлэн бүртгэсэн ба аймгийн төрийн санд төлөх ёстой өрийн хэсэг байна.

Цахилгаан шугам сүлжээний газарт Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Цахилгааны шугамын шинэчлэл, алдагдал бууруулах” төслөөр 2009 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 2,136.6 сая төгрөгийн зээл бүртгэлтэй бөгөөд өр төлбөр дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй, төлөлт хийгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Ногооннуур сумын ОНХС-гийн 36.6 сая төгрөгийн тодорхой эзэнгүй өр төлбөрийг дансанд бүртгэж, тайлагнасан.
- Аймгийн Засаг даргын тамгын газрын “Нээлттэй Баян-Өлгий 2023 эдийн засгийн форум чуулга уулзалт”-ын 2023 онд зохион явуулсантай холбоотой гарсан зардлыг 2023 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй боловч Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2024 онд 7.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна.
- Барилга захиалагчийн албаны санхүүгийн тайлангаар 3.6 сая төгрөгийн өглөгийг зөрүүтэй тайлагнасан.
- Цахилгаан шугам сүлжээний газрын тайлангаар 23 аж ахуйн нэгжтэй холбоотой өглөгийн 91.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
- Дэлүүн ОНХС нь сумын ИТХ-ын тогтоолоор баталсан арга хэмжээг журмын дагуу оновчтой зохион байгуулж хэрэгжүүлээгүйгээс оны эцэст 43 төсөл, арга хэмжээтэй холбоотой 514.8 сая төгрөгийн өглөгтэй гарсан.

#### 4.7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 134,878.7 сая төгрөг болж, өмнөх оноос 14,021.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №14. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,819.5	38,987.3	1,167.8	28.9
<b>Дүн</b>	<b>83,037.9</b>	<b>95,891.4</b>	<b>12,853.5</b>	<b>71.1</b>
Өмнөх үеийн үр дүн	40,000.2	69,163.6	29,163.4	51.3
Тайлант үеийн үр дүн	28,003.1	11,650.9	(16,352.2)	8.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,034.6	15,076.9	42.3	11.18
<b>Дүн</b>	<b>120,857.4</b>	<b>134,878.7</b>	<b>14,021.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 1,135.7 сая төгрөг, төсөвт байгууллагын 32.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### 4.8 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн шууд захирагч, аж ахуй нэгж, төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Аудитад Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 42 төсвийн байгууллага, 28 тусгай сан /ОНХС, ХХС/, орон нутгийн өмчит аж ахуйн 4 нэгж, 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 88 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан хамрагдсан байна. ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд ороогүй аймгийн Барилга захиалагчийн албаны санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 32 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, сумдын ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн олон нийтийн радио телевиз, Сум дундын ойн анги, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Асрамжийн газар, Хот тохижуулах алба, Өрхийн Эрүүл мэндийн төвүүд, Нийгмийн халамжийн сан, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, сумын Хоршоо хөгжүүлэх сан, орон нутгийн өмчит 2 газар, бүгд 56 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж баталгаажуулсан.

Аудитаар 17 байгууллагын санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй”, 15 байгууллагын санхүүгийн тайланд “хязгаарлалтай” дүгнэлт өгсөн.

Хүснэгт №15. Өөрчлөлттэй дүгнэлт өгсөн төсвийн шууд захирагч, аж ахуй нэгж, төвлөрүүлэн захирагчид

1 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9 Ногооннуур сумын Засаг дарга
2 Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар	10 Сарсай сумын Засаг дарга
3 Улаанхус сумын Засаг даргын тамгын газар	11 Толбо сумын Засаг дарга
4 Цагааннуур тосгоны захирагчийн алба	12 Улаанхус сумын Засаг дарга
5 Цахилгаан шугам сүлжээний газар	13 Цагааннуур тосгоны Захирагч
6 Алтай сумын Засаг дарга	14 Цэнгэл сумын Засаг дарга
7 Буянт сумын Засаг дарга	15 Өлгий сумын Засаг дарга

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийтдээ 15,169.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, үүнээс 5,777.0 сая төгрөгийн алдааг залруулж, 93.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,901.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 5,359.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 4 албан тушаалтанд 38.1 сая төгрөгийн сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

### **Орон нутгийн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар:**

Аудитад 42 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан хамрагдсанаас 16 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 26 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан баталгаажуулсан. Аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт 12, хязгаарлалттай 4 /аймгийн ИТХ, Ногооннуур, Улаанхус сумын ЗДТГ, Цагааннуур тосгоны захирагчийн алба/ дүгнэлт өгсөн.

ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,541.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 5,164.5 сая төгрөгийн алдааг залруулан, 93.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,594.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,650.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 3 албан тушаалтанд 38.1 сая төгрөгийн сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

### **Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

Аудитад 4 орон нутгийн өмчийн газрын санхүүгийн тайлан хамрагдаж, 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. “Суат” ХХК-ны санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт, ЦШСГ-ын санхүүгийн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт өгч, “Хала өркени” ОНӨААТҮГ, Барилга захиалагчийн албаны санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,750.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 7.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1,307.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 435.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт: Орон нутгийн өмчит газруудын санхүүгийн тайлангаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ЦШСГ нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, оны эцэст 14 аж ахуйн нэгжтэй холбоотой авлагын, 23 аж ахуйн нэгжтэй холбоотой өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
- Суат ХХК нь санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт байгууллагаас авах авлагыг 6.4 сая, ААН-ээс авах авлагыг 1.3 сая төгрөг бүгд 7.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээллийг хангалтгүй хөтөлсөн.
- БЗАлба нь санхүүгийн тайланг буруу тайлагнасан, авлага, өглөгийг илүү, дутуу зөрүүтэй гаргасан, цалингийн зардлын гүйцэтгэл зөрүүтэй, ажиллагсад олгосон цалин, урьдчилгаа, НДШ-ийн тооцооллыг алдаатай тооцоолсон, бараа материалын тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, үндсэн хөрөнгө, бараа материал тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

### **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:**

Аудитад 14 сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан хамрагдсан. Үүнээс Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт, Алтай, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Цагааннуур тосгон, Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 877.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 604.8 сая төгрөгийн алдааг залруулж, 272.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт: *ТТЗ-ийн санхүүгийн тайлангаар дараах зөрчлүүд илэрсэн.*

- 14 сумын ТТЗ-д сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан гаргалт, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хангалгүй хэрэгжүүлснээс аудитаар илэрсэн зөрчлийн хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн. Сумын Засаг дарга, санхүүгийн албад харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулах, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах талаар зөвлөмж өгөгдлөө.
- Толбо сумын ТТЗ нь аймгийн орон нутгийн төсвөөс сумын төсөвт байгууллагуудад олгох халаалтын зардлын төсвөөс шинэчлэн баталсан тариф батлагдаагүй гэсэн шалтгаанаар олгоогүй, орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн, сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орсон 22.3 сая төгрөгийн өвс тэжээл худалдсаны орлогыг зарцуулалтын эрх аваагүй зарцуулсан.

### **ТЕЗ-ийн харьяа Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:**

Боловсролын салбарын 99 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийснээс 62 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 37 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан баталгаажуулсан. Аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт 59, хязгаарлалттай 3 /Дэлүүн, Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Өлгий сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг/ дүгнэлт өгсөн.

Боловсролын салбарын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 39,999.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 30,703.4 сая төгрөгийн алдааг залруулан, 64.4 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт, 3,045.7 сая төгрөгийн зөрчилд 93 албан шаардлага, 6,185.5 сая төгрөгийн зөрчилд 134 зөвлөмж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 11 албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

Эрүүл мэндийн салбарын 17 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийснээс 6 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 11 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан баталгаажуулсан. Аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт 10, хязгаарлалттай 1 /Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв/ дүгнэлт өгсөн.

Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,953.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 3,770.1 сая төгрөгийн алдааг залруулж, 19.5 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, 1,500.5 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 663.0 сая төгрөгийн зөрчилд 19 зөвлөмж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Соёлын салбарын 19 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийснээс 1 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 18 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан баталгаажуулсан.

Соёлын салбарын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 549.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 225.0 сая төгрөгийн алдааг залруулж, 8.6 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт, 68.2 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 247.2 сая төгрөгийн зөрчилд 17 зөвлөмж өгсөн.

#### **4.9 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

#### **4.10 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 13.4 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын шийдвэрээр 2021 онд татан буугдсан “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын он дамжсан 506.3 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах албан шаардлагын дагуу аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж аймгийн ОНХС-д төлөх 200.0 сая төгрөгийн өглөгийг тухайн үед хөрөнгө, тавилга эд хогшил бэлтгэж орлогод авсан учраас хөрөнгө оруулалт хийснээр тооцож, өглөгөөс хасах санал гаргасан. ТЭЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар дээрх 506.3 сая төгрөгийн өр төлбөрийг 2024 оноос эхлэн сангийн яамны Э-тайлан программ хаагдаж, санхүүгийн тайлангийн “Fin Perform” шинэ системд шилжиж байгаатай холбогдуулан татан буугдсан байгууллагыг шинэ системд бүртгэх боломжгүй, мөн тухайн байгууллагын өр төлбөрийг нэхэмжилж байгаа тодорхой эзэн байхгүй зэрэг шалтгааныг үндэслэн 306.3 сая төгрөгийн /бараа үйлчилгээний зардлын өглөг 39.5 сая, хувь хүмүүст төлөх 44.7 сая, татварын өглөг 4.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 13.7 сая, төлбөртэй ажил үйлчилгээний өглөг 66.1 сая, мөн хувь хүмүүст төлөх 138.0 сая төгрөг/ тухайн байгууллагын тайланд хаалтын баланс хийж, өр төлбөрийг балансын гадуур бүртгэж тэмдэглэсэн байна.
- “Суат” ХХК-ны урт хугацаат зээлийн өглөгт орон нутгийн төсвөөс төлсөн 430.5 сая төгрөгийн авлага, мөн ТЭЗ-ийн СНТ-д олон жил он дамжин бүртгэгдэж байгаа тодорхой эзэнгүй 250.4 сая төгрөгийн авлага барагдаагүй, Өлгий сумаас аймагт төвлөрүүлэх тэгшитгэлийн 304.3 сая төгрөгийг авлага тус сумын орлогын төлөвлөгөө тасарснаас барагдаагүй байна.

Орон нутгийн 2024 оны сонгуулийн үр дүнгээр өмнөх ажиллаж байсан аймгийн удирдах албан тушаалтнууд ажлаас гарсан тул хариуцлага тооцох боломжгүй байна.

#### **4.11 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлж, 2024 онд 7 албан хаагчидтай, үүнээс санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч 3, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч 2 аудитор ажиллаж байна.

Тус алба 2024 онд 104 төсвийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, аймгийн 226 байгууллагын шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. Хяналт шалгалтын дүнгээр 34.8 сая төгрөгийн акт тогтоож, 665.1 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгч, урьд оны төлөгдөөгүй актын төлбөрөөс 4.2 сая төгрөгийг, тайлант оноос 16.6 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### 4.12 ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ГАЗРУУДЫН ТАЛААР

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нэгтгэгдсэн байна.

Хүснэгт №16 ОНӨҮГ-ын ашиг, алдагдлын талаар

№	Аж ахуйг нэгжийн нэр	Тайлан он	/сая төгрөгөөр/ Гүйцэтгэл		
			Орлого	Зардал	Ашиг +, алдагдал -
1	ЦШСГазар ОНӨҮГ	2024	17,830.7	17,688.0	142.7
2	"Суат" ХХК ОНӨҮГ	2024	2,339.80	2,149.40	190.4
3	"Хала өркени" ОНӨҮГ	2024	72.00	145.50	(73.5)

Тайлант онд ЦШСГ болон "Суат" ХХК нь ашигтай ажилласан байна. ЦШСГ ашигтай ажиллаж байгаа нь цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг индексжүүлж, борлуулах зарим цахилгааны чадлын тарифыг шинэчлэн тогтоосонтой холбоотой, "Суат" ХХК нь цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл, өрх, аж ахуйн нэгжүүдийг тоо нэмэгдсэн, цэвэр бохир ус борлуулах үнэ тариф шинэчилэгдсэнтэй холбоотой 2024 онд ашигтай ажилласан байна.

"Хала өркени" ОНӨҮГ нь "Хүүхэд залуучуудын парк ажиллуулах, түүний тохижилт, засвар үйлчилгээ"-ний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд улирлын чанартай үйл ажиллагаа явуулдгаас үндсэн үйл ажиллагааны орлого бага, ажиллагсдад олгох цалин, татвар, НДШ-ийн өглөг өмнө оноос нэмэгдсэн, жил бүр алдагдалтай ажиллаж байна.

### 5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

#### 5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх авлага өмнөх оноос 514.8 сая төгрөгөөр өссөн нь төрийн сан, ОНӨҮГ-ын авлага нөлөөлсөн байна.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх өглөг өмнөх оноос 3,054.6 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар дуусаагүй барилга, байгууламж дансанд аймгийн Асрамжийн газрын ашиглалтад ороод 2 жил болсон барилгыг барилга, байгууламжийн дансанд бүртгэж аваагүй байна.
4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага бүрэн хэрэгжээгүй байна.

#### 5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

##### I. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-Д:

1. Орон нутгийн төсвөөс "Суат" ХХК-нийн урт хугацаат зээлийн төлбөрт төлсөн тооцооны авлагыг барагдуулах арга хэмжээ авах;

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

2. Аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд олон жил он дамжин бүртгэгдэж байгаа төлөгдөх эсэх нь тодорхойгүй авлага, Өлгий сумаас аймагт төвлөрүүлэх тэгшитгэлийн авлагыг шийдвэрлэх арга хэмжээ авах;
3. Аймгийн ИТХ-ын шийдвэрээр татан буугдсан “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын 306.3 сая төгрөгийн өр төлбөрийг программын шинэчлэлтэй холбоотой хаалтын бичилт хийж, балансаас гадуур бүртгэснийг Аймгийн Засаг даргын дансанд өр төлбөрөөр бүртгэх;

## **II. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА-Д:**

1. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 93.5 сая төгрөгийн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулах, 3,892.5 сая төгрөгийн албан шаардлага, 5,379.3 сая төгрөгийн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аймгийн ИТХ	3	15,134.5			3	15,134.5	3	15,134.5				
СХДААлба	1	1,375.5			1	1,375.5	1	1,375.5				
ОНӨГазар	13	193,196.6			13	193,196.6	13	193,196.6				
Асрамжийн газар	2	597,827.7	2	597,827.70			2	597,827.7				
Алтай сумын ЗДТГ	9	355,831.7	3	170,597.70	6	185,234.0	9	355,831.7				
Алтай сумын ИТХ	2	26,565.1			2	26,565.1	2	26,565.1				
Улаанхус сумын ЗДТГ	5	178,755.2			5	178,755.2	5	178,755.2				
Улаанхус сумын ИТХ	2	76,935.4	1	70,335.40	1	6,600.0	2	76,935.4				
Бугат сумын ЗДТГ	3	46,020.4			3	46,020.4	3	46,020.4				
Сагсай сумын ЗДТГ	2	47,662.2			2	47,662.2	2	47,662.2				
Сагсай сумын ИТХ	1	21,628.8			1	21,628.8	1	21,628.8				
Дэлүүн сумын ЗДТГ	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
Ногооннуур сумын ЗДТГ	2	62,362.9			2	62,362.9	2	62,362.9				
Ногооннуур сумын ИТХ	1	77,657.2			1	77,657.2	1	77,657.2				
Толбо сумын ЗДТГ	3	1,088,232.9			3	1,088,232.9	3	1,088,232.9				
Толбо сумын ИТХ	1	9,328.9			1	9,328.9	1	9,328.9				
Цагааннуур тосгоны захирагчийн алба	10	306,600.0			10	306,600.0	10	306,600.0				
Булган сумын ИТХ	1	9,993.6			1	9,993.6	1	9,993.6				
Баяннуур сумын ЗДТГ	1	18,250.0			1	18,250.0	1	18,250.0				
Баяннуур сумын ИТХ	4	4,640.6			4	4,640.6	4	4,640.6				
Жансая ӨЭМТөв	4	95,073.6			4	95,073.6	4	95,073.6				
Шипагер ӨЭМТөв	5	179,600.1	5	179,600.10			5	179,600.1				
Мейрим ӨЭМТөв	1	28,263.0			1	28,263.0	1	28,263.0				
Раушан ӨЭМТөв	3	158,050.7			3	158,050.7	3	158,050.7				
Бугат сумын ОНХС	1	3,500.0	1	3,500.00			1	3,500.0				
Бугат сумын ХХС	1	9,467.4	1	9,467.40			1	9,467.4				
Цэнгэл сумын ОНХС	1	1,230,080.2	1	1,230,080.20			1	1,230,080.2				
Толбо сумын ХХС	1	130,000.0			1	130,000.0	1	130,000.0				
Улаанхус сумын ОНХСан	1	182,466.2	1	182,466.20			1	182,466.2				
Орон нутгийн өмчийн "Суат" ХХК	1	7,732.6			1	7,732.6	1	7,732.6				
Баяннуур сумын ТТЗ	1	236,455.9			1	236,455.9	1	236,455.9				
Өлгий сумын ТТЗ	1	368,339.0			1	368,339.0	1	368,339.0				
<b>Нийт дүн</b>	<b>88</b>	<b>5,777,027.9</b>	<b>15</b>	<b>2,443,875</b>	<b>73</b>	<b>3,333,153.2</b>	<b>88</b>	<b>5,777,027.9</b>	-	-	-	-

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

**Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ИТХ	4	164,784.5	1	496.0	2	153,622.4	1	10,666.1				
Аймгийн ЗДТГ	6	172,978.5	1	19,579.4	2	109,846.0	3	43,553.1				
СХДААлба	2	7,646.7	1	4,046.7	1	3,600.0		-				
БОАЖГазар	2	26,129.5	1	726.0		-	1	25,403.5				
ОНӨГазар	1	1,422.2	1	1,422.2		-		-				
Худалдан авах ажиллагааны газар	1	2,849.4	1	2,849.4		-		-				
Нийгмийн халамжийн сан	1	63,678.0		-		-	1	63,678.0				
Асрамжийн газар	2	459,839.1		-	1	163,149.3	1	296,689.8				
ОНРТ	1	-		-		-	1	-				
Өлгий сумын ХТА	2	85,312.5	1	310.1	1	85,002.4		-				
Алтай сумын ЗДТГ	5	172,498.7	2	5,221.4	2	164,707.0	1	2,570.3				
Алтай сумын ИТХ	1	776.1	1	776.1		-		-				
Алтанцөгц сумын ЗДТГ	7	20,143.6	2	4,862.2	1	2,923.0	4	12,358.4				
Алтанцөгц сумын ИТХ	-	-		-		-		-				
Баяннуур сумын ЗДТГ	4	164,532.7		-		-	4	164,532.7				
Баяннуур сумын ИТХ	1	715.0		-		-	1	715.0				
Бугат сумын ЗДТГ	2	10,039.5	1	5,359.5	1	4,680.0		-				
Булган сумын ЗДТГ	2	2,835.6	1	2,835.6		-	1	-				
Буянт сумын ЗДТГ	1	3,698.5	1	3,698.5		-		-				
Буянт сумын ИТХ	1	957.0	1	957.0		-		-				
Өлгий сумын ЗДТГ	3	43,751.9	1	4,884.9	2	38,867.0		-				
Өлгий сумын ИТХ	9	133,893.4	3	12,043.7	2	107,319.0	2	14,530.7	2			
Улаанхус сумын ЗДТГ	7	133,614.6	2	3,430.0	4	86,952.0	1	43,232.6				
Улаанхус сумын ИТХ	1	958.2	1	958.2		-		-				
Сагсай сумын ЗДТГ	3	5,474.3	2	4,791.7		-	1	682.6				
Сагсай сумын ИТХ	2	14,411.0	1	911.0	1	13,500.0		-				
Цэнгэл сумын ИТХ	1	958.3	1	958.3		-		-				
Цэнгэл сумын ЗДТГ	1	3,922.2	1	3,922.2		-		-				
Дэлүүн сумын ЗДТГ	4	48,792.8		-	2	19,092.8	2	29,700.0				
Дэлүүн сумын ИТХ	1	500.0	1	500.0		-		-				
Ногооннуур сумын ЗДТГ	5	126,426.8	1	6,068.4	3	31,258.4	1	89,100.0				
Ногооннуур сумын ИТХ	4	63,943.6	1	613.7	2	13,211.2	1	50,118.7				
Толбо сумын ЗДТГ	2	16,264.4		-		-	2	16,264.4				
Толбо сумын ИТХ												
Цагааннуур тосгоны ЗА	7	175,806.4	1	1,281.7	1	12,332.9	5	162,191.8				
Жансая ӨЭМТөв	1	109,062.9		-		-	1	109,062.9				
Раушан өрхийн ӨЭМТөв	1	124,506.9		-		-	1	124,506.9				
Булган сумын ОНХС	1	44,000.0		-	1	44,000.0		-				
Өлгий сумын ОНХС	2	470,400.0		-	2	470,400.0		-				
Сагсай сумын ХХС	1	16,851.1		-		-	1	16,851.1				
Цэнгэл сумын ХХС	1	88,256.5		-		-	1	88,256.5				
Цэнгэл сумын ОНХС	1	60,000.0		-	1	60,000.0		-				
Дэлүүн сумын ОНХС	1	571,271.4		-	1	571,271.4		-				
Ногооннуур сумын ХХС	1	39,734.3		-	1	39,734.3		-				
Ногооннуур сумын ОНХС	3	170,565.0		-	2	134,000.0	1	36,565.0				
Буянт сумын ОНХС	2	13,500.0		-		-	2	13,500.0				
Буянт сумын ХХС	1	128,941.9		-	1	128,941.9		-				
Цагааннуур сумын ОНХС	1	11,000.0		-		-	1	11,000.0				
Орон нутгийн өмчийн "Суат" ХХК	1	150,146.4		-	1	150,146.4		-				
ЦШСГазар ОНӨААТҮГ	2	1,088,284.1		-	1	1,088,284.1		-	1			
Барилга захиалагчийн алба	1	68,673.3		-	1	68,673.3		-				
Алтай сумын ТТЗ	2	-		-		-	2	-				
Алтанцөгц сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Баяннуур сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Бугат сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Буянт сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Булган сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Сагсай сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Толбо сумын ТТЗ	2	272,879.9		-		-	2	272,879.9				
Улаанхус сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Ногооннуур сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Цэнгэл сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Цагааннуур тосгоны ТТЗ	1	-		-		-	1	-				
Дэлүүн сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
Өлгий сумын ТТЗ	1	-		-		-	1	-				
<b>НИЙТ ДҮН</b>	<b>133</b>	<b>5,557,628.5</b>	<b>32</b>	<b>93,503.7</b>	<b>40</b>	<b>3,765,514.8</b>	<b>58</b>	<b>1,698,610.0</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын бүртгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Алтай сумын ИТХ	1	11,471.0					1	11,471.0		
Алтай сумын ЗДТГ	1	38,154.7							1	38,154.7
Сагсай сумын ЗДТГ	1	75,510.0					1	75,510.0		
Буянт сумын ЗДТГ	1	22,000.0					1	22,000.0		
Толбо сумын ЗДТГ	1	18,004.6					1	18,004.6		
Аймгийн ЗДТГ	1	2,558,876.6					1	2,558,876.6		
Толбо сумын ИТХ	1	13,962.6					1	13,962.6		
Асрамжийн газар	1	9,011.5			1	9,011.5				
ХТАлба	1	242,825.9					1	242,825.9		
Аймгийн ИТХ	1	18,145.1					1	18,145.1		
СХДАА	1	41,069.1					1	41,069.1		
Өлгий сумын ИТХ	1	126,964.4			1	126,964.4				
Улаанхус сумын ХХС	1	100,000.0					1	100,000.0		
Буянт сумын ОНХС	1	73,300.0					1	73,300.0		
Цэнгэл сумын ОНХС	1	-					1			
Цагааннуур тосгоны ОНХС	1	50,000.0					1	50,000.0		
Орон нутгийн өмчийн "Суат" ХХК	1	435,550.7					1	435,550.7		
<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>3,834,846.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>135,975.9</b>	<b>14</b>	<b>3,660,715.6</b>	<b>1</b>	<b>38,154.7</b>

  
**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/10

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэхь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2024 оны жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитын ажлын болон нотлох баримтыг ажлын 7 хоногийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг хариуцсан ахлах аудитор (Д.Назгүл)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т даалгасугай.



Ж.АЙГҮЛ

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан